



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХӨРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V баир
Утас/Факс: (976-51) 26 75 33 E-mail: foreign@mofha.gov.mn
http://www.mofha.gov.mn


2018.05.11 № 1-1/2384

таныг 2018.04.16 -ны № 21 -1

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН М.ОЮУНЧИМЭГ
ТАНАА

Таны 2018 оны 04 дүгээр сарын 16-ны
өдрийн 21 тоот асуулгын хариуг үүгээр хүргүүлж
байна.

Хавсралт: 14 хуудастай.



М. ОЮУНЧИМЭГ

Doc 08 1808

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн 11238 тоот албан бичгийн хавсралт.

АСУУЛГЫН ХАРИУ

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон эдгээрийг дагаж гарсан журмуудаар хүүхдийн эрхийг хангахад төр, иргэн, хуулийн этгээдийн оролцоо болон хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Мөн 2017 оноос Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулиар зүйлчилж, Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэж эхэлсэн.

Цагдаагийн байгууллагын тоо мэдээгээр 2015-2017 онд хүчиндэх гэмт хэргийн улмаас 950 хүн хохирсны 936 эмэгтэй, 14 эрэгтэй хүн байна. Энэ хугацаанд 6 хүний амь нас хохирч, 262 хүн гэмтсэн ба нийт хохирсон хүмүүсийн 469 буюу 49,4 хувь нь 18 хүртэлх насны хүн байлаа. /Хүснэгтээр харуулав/.

Хүснэгт 1. Монгол Улсад 2010-2017 онд үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг¹

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Улсын хэмжээнд	342	367	305	344	300	279	290	376
Нийслэлд	157	180	155	182	152	133	132	194
Орон нутагт	185	187	150	162	148	146	158	182

Харин бэлгийн хүчирхийлэлд өртсөн бага насны охидын тоо 2010 онд 152 байсан бол 2017 онд 187 хүүхэд энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирчээ.

Хохирогчийг насны байдлаар харуулбал: 49,4 хувь нь насанд хүрээгүй хүн, тодруулбал: 7 хүртэлх насны хүүхэд 45 буюу 4,7 хувь, 8-13 насны хүүхэд 151 буюу 15,8 хувь, 14-17 насны хүүхэд 273 буюу 28,7 хувь, 18-24 насны хүн 209 буюу 22 хувь, 60 дээш насны хүн 11 буюу 1,1 хувийг эзэлж байна.

“Хүчиндэх” гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдсан хүмүүсийн 97 буюу 10,1 хувь нь “Ураг төрлийн хамааралтай” хүмүүс бөгөөд тэдний 44,3 хувь нь хойд эцэг, 18,5 хувь нь төрөл садангийн хүн, 12,3 хувь нь төрсөн эцэг, 10,3 хувь нь хүргэн.

¹ Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар

График 1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн орчин²





График 2. Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн ангилал³



² Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

³ Эх сурвалж: Улсын Ерөнхий Прокурорын газар

График 3. 2018 оны эхний улиралд хүүхэд хохирсон хэргийн шийдвэрлэлтийн байдал⁴



Хүснэгт 2. Улсын хэмжээнд Эрүүгийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо⁵

Он	Гэмт хэргийн тоо	ГБХ-ийн улмаас амь хохирсон хэргийн тоо		ГБХ-ийн улмаас хүнд гэмтсэн хэргийн тоо		ГБХ-ийн улмаас хүндэвтэр гэмтсэн хэргийн тоо		ГБХ-ийн улмаас хөнгөн гэмтсэн хэргийн тоо	
		Нийт	Насанд хүрээгүй хүн	Нийт	Насанд хүрээгүй хүн	Нийт	Насанд хүрээгүй хүн	Нийт	Насанд хүрээгүй хүн
2014		11	3	9	1	12	2	44	6
2015		19	4	10	1	11	0	36	3
2016		16	4	15	2	29	3	53	8
2017	67	19	5	21	3	31	2	405	39
Нийт	67	65		55		83		538	


Эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр 2017 онд хүчирхийллийн шалтгаанаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан нийт 17,309 тохиолдлын 1,835 тохиолдол буюу 10,6% нь хүүхэд байжээ. Тухайлбал: Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн Өсвөр үеийн клиник 2017 онд 3661 хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлснээс хүчирхийлэлд өртсөн 58 хүүхэд байсан ба тэдний 89,7% нь бэлгийн хүчирхийлэл, 10,3% нь бие махбодын, үл хайхрах, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байв.

Харин Гэмтэл согог судлалын үндэсний төвд 2017 онд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн нийт 910 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс 299 нь 0-16 насны хүүхэд байлаа.

⁴ Эх сурвалж: Улсын Ерөнхий Прокурорын газар

⁵ Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл

График 4. СЭМҮТ-ийн Хүүхэд, өсвөр үеийн клиникээр хүчирхийллийн улмаас хэвтэн эмчлүүлэгчийн тоо⁶



Гэр бүлийн хүчирхийлэл, тэр дундаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн гаралт буурахгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлох, түүнийг арилгах зорилгоор Засгийн газар зүгээс Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

Нэг: Хүүхдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох чиглэлээр:

1. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Монгол Улс дахь гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, хэтийн төлөв хандлагыг нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай харьцуулан, шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, түүнтэй тэмцэх арга замыг тодорхойлон төр засаг, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад санал, зөвлөмж болгох зорилгоор Монгол Улсад анх удаа “Гэмт хэргийн цагаан ном-2016” товхимлыг гаргасан.

Уг товхимлын 5 дугаар бүлэгт Гэр бүлийн хүчирхийлэл ба гэмт явдал, 6 дугаар бүлэгт Хүүхэд холбогдсон, хохирсон гэмт явдал, 18 дугаар бүлэгт бэлгийн мөлжлөг ба хүчиндэх гэмт явдлыг тус тус авч судалсан болно.

Уг судалгаагаар хүүхдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Гэр бүлийн орчин, сургуулийн өмнөх боловсрол, дунд сургууль, их сургуульд хүчирхийлэл, гэмт хэрэг, харилцааны талаар үндсэн болон нэмэлт мэдлэг, хандлага өөрчлөх, чиглэлээр хичээл орохгүй явж ирснээс шалтгаалж нийгэм тэр чигтээ хүчирхийлэлд дасан зохицох хандлага;
- Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Гэр бүлийн хүчирхийллийн гомдол, мэдээллийн 70 гаруй хувьд хамаарах тохиолдол нь архидан согтуурсан үедээ үйлдсэн;
- Гэр бүлийн таагүй уур амьсгал (эцэг, эхийн архидалт, хүүхэдтэйгээ харгис хэрцгий хандах, хүмүүжлийн буруу арга), сургуулийн орчин дахь эрх зүй, зан суртахууны ба хүйсийн харилцааны алдаа, хувь хүний сэтгэц физиологийн онцлог, хохирогчийн буруутай үйлдэл, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг сурталчилгааны нөлөө;

⁶ Эх сурвалж: Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэний төв


- Хүчирхийлэгчийн нийтлэг байдлыг авч үзэхэд хохирогчийн танил, 18-35 насны, ажилгүй, бүрэн дундаас доош боловсролтой, эрэгтэй хүмүүс.

2. Цагдаагийн байгууллагаас насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэг үйлдэж байгаа, хүүхэд гэмт хэрэгт өртөж хохироод байгаад криминологи судалгаа хийж, шалтгаан нөхцөлийг нарийвчлан судлах, дахин давтах гэмт хэрэг болон дараа дараагийн бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хууль сахиулахын их сургуульд “Монгол Улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” судалгааг захиалж 2013-2017 оны байдлаар гүйцэтгүүлсэн.

Тус судалгаагаар тодорхойлсон шалтгаан нөхцөлөөс:


- Ёс суртахууны үнэт зүйлсийн мэдрэмжгүй байдал, ажилгүйдэл, ядуурал, гэр бүлийн байдал, нийгмийн хяналт, гаж буруу зан үйл, хүмүүсийн ухамсар, зан төлөвт доголдол гарч, үүрэг хариуцлага, ичих, гэмшихийг умартсан байдал;
- Нийгмээс тусгаарлагдмал байдал;
- Олон нийтийн цахим сүлжээний хяналтгүй хэрэглээ;
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоогүй байдал.

График 5. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгчийн нийгмийн байдал⁷




⁷ Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар

График 6. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгчийн насны ангилал⁸



3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, хэрэг шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор 2014-2017 оны байдлаар “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх нь” судалгааг “Хөгжлийн академи” ТББ-аар гүйцэтгүүлжээ.

График 7. Хүүхдийн хүчирхийлэл үйлдэгдсэн орчин⁹



4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран бичил уурхай болон албажаагүй ил уурхайд хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоон мэдээллийг гаргах, нөхцөл байдалтай нь танилцах зорилгоор 11 аймагт хийсэн судалгаагаар 8-18 насны 1498 хүүхэд уурхайд хөдөлмөр эрхэлж байгааг тогтоосон бөгөөд судалгаанд оролцсон хүүхдүүдийн дийлэнх нь гэр бүлээ даган уурхайд ажиллаж байсныг илрүүлэв.

⁸ Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар

⁹ Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Дээрх судалгаануудаас шалтгаан нөхцөлийг дүгнэвэл:

Бага насны хүүхдийг хүчиндсэн, хүчиндэхийг завдсан, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэмт хэрэг үйлдэгчдийн 85 хувь нь хохирогчийн ойрын төрөл садны хүмүүс буюу төрсөн болон хойд эцэг, хамаатан, танил хүмүүс байна. Иймээс бага насны хүүхэд тэдэнд итгэх, дагаж явах, хэлсэн үгэнд нь хууртах зэргээр гэмт халдлагад өртөх нөхцөл бүрддэг.

Нөгөө талаас эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлж байгаагийн улмаас энэ төрлийн гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл бүрдэж байна.

Хохирогчдын 26,3 хувь нь бэлгийн хүчирхийлэлд давтан өртсөн. Үүнээс 30,4 хувь нь 3-7 жилийн хугацаанд бэлгийн хүчирхийлэлд байснаас үзэхэд, бага насны хохирогч хүүхдийн хувьд хүчирхийлэгч хэргийн талаар хүнд хэлэхгүй байхыг шаардах, айлган сүрдүүлэх, дарамтлах зэрэг нь тэдний сэтгэл зүйд хүчтэй нөлөөлдөг ба хохирогч болсон явдлыг удаан хугацаагаар бусдаас нуух, ичих, айх зэрэг байдлаас шалтгаалан тухайн хүчирхийлэгчийн халдлагад дахин өртөх, бие махбодын болон сэтгэл зүйн хүнд хор уршиг бий болох зэрэг нөхцөл бүрддэг.

Мөн хүүхдэд зориулсан биеийн тамирын талбай, тоглоомын төв, усан бассейн, спортын цогцолбор, хүүхдийн ордон зэрэг чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх газар хомс, үйл ажиллагаа явуулж байгаа зарим газрууд нь өндөр төлбөртэй байгаагаас зөвхөн цахим тоглоом тоглох, хараа хяналтгүй гадуур тэнэх зэргээр чөлөөт цагаа өнгөрөөж байгаа нь гэмт хэрэгт холбогдох нөхцөлийг бүрдүүлж байна. Мэдээллийн технологи, цахим орчин, гар утас нь хувь хүн, нийгмийн амьдралд шинэ дэвшлийг авч ирсэн хэдий ч хүүхдийн тухайд садар самуун, хүчирхийлэл, гэмт хэрэг, донтолт, ганцаардлыг бий болгох гол нөхцөл болж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт үйлдэл нь архидан согтуурах явдалтай шууд холбоотой байх тул нийгмийн шинжтэй дээрх асуудлыг зөвхөн хууль сахиулах байгууллагын үүрэг оролцоогоор хязгаарлахгүй согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгодог Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, согтууруулах ундаа борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл өгч буй аймаг, нийслэлийн Засаг дарга нар, хяналт тавих мэргэжлийн хяналтын газар, эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн байгууллага, соён гэгээрүүлэх чиглэлийн Төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагын энэ талаархи чиг үүргийг тодорхой болгож хамтран ажиллах шаардлагатай байна.

Энэ чиглэлээр 2018 онд хийгдэж буй судалгааны ажлаас дурдвал:

1. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн захиалгаар -Монгол Улсад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн өсөлт бууралтын криминологи судалгаа, -насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл, шийдвэрлэлт суурь судалгаа, -хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгчийн нийтлэг болон онцлог дүр төрийг тодорхойлох хавсарга судалгаа, -хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт, шийдвэрлэлт суурь судалгаа, -гэр бүлийн хүчирхийллийн улмаас бусдыг санаатай алах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, шийдвэрлэлт суурь судалгааны ажлыг тус тус эхлүүлэв.

2. "Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021)"-ийн 2018-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан Хүүхдийн эсрэг хүчирхийллийн

судалгаа, Хүүхдийн хөдөлмөрийн судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран хийхээр тус тус батлагдсан.

Засгийн газраас Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд:

Засгийн газраас Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг дагаж гарсан 10 журам, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж гарсан 34 журмыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан тушаалаар "Өсвөрийн сэргийлэгч бүлгэм" ажиллах журам батлагдсан. Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар орон нутагт 22, нийслэлд 82 ерөнхий боловсролын сургууль дээр "Өсвөрийн сэргийлэгч" бүлгэм байгуулагдаж, цагдаагийн байгууллагын алба хаагчид тэдэнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж эхэлсэн.

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний цогц хөтөлбөр /2017-2021/-ийг Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор батлан, хөтөлбөрийг 2018-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн салбарт:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/27 дугаар тушаалаар Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дор Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Уг Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох яам, агентлаг, төрийн бус байгууллагын 14 төлөөлөл орж ажилладаг.

Дэд зөвлөлийн хүрээнд салбар дундын хамтын ажиллагааг хангах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг нэг мөр ойлгох, хэрэгжилтийг хангах, үүрэг бүхий алба хаагч нарыг чадавхижуулах зорилгоор Улаанбаатар хотод 21 аймаг, 9 дүүргийн цагдаа, эрүүл мэнд, нийгэм, халамжийн байгууллагын дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нар "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа" сэдэвт Үндэсний чуулганыг 2017, 2018 онд зохион байгуулсан.

Мөн 2018 онд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа" бүсийн зөвлөгөөн зохион байгуулах ажлын хүрээнд 03 дугаар сард Зүүн бүсийн зөвлөгөөнийг Дорнод аймаг, 05 дугаар сард Хангайн бүсийн зөвлөгөөнийг Орхон аймагт тус тус зохион байгууллаа. Энэхүү бүсийн зөвлөгөөнд сумын Засаг дарга нар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн нэгжийн алба хаагч, нийгмийн

ажилтан, эрүүл мэндийн ажилтан, боловсролын ажилтнуудыг хамруулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Мөн "Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, уялдаа холбоог бэхжүүлэх сургалт"-ыг хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагч, шүүгч, өмгөөлөгч, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалтыг зохион байгуулж байна. Одоогийн байдлаар 10 аймгийн 500 хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагч, шүүгч, өмгөөлөгч нарыг сургалаа.

Монгол улсад сүүлийн жилүүдэд хүүхдээс үйлдсэн болон хүүхэд хохирсон гэмт хэргийн гаралт өсөн нэмэгдэх хандлагатай байгаад криминологи судалгаа хийж хүүхдийг гэмт халдлага, хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг идэвхжүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр А/234 дүгээр тушаалаар Урьдчилан сэргийлэх хэлтсийн бүтцэд Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасаг, Нийслэлийн цагдаагийн газарт Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийг тус тус байгуулав.

Цагдаагийн байгууллагын дуудлага, мэдээллийн нэгдсэн санд 2018 оноос шинээр Гэр бүлийн хүчирхийллийн талаар өргөдөл, гомдол бүртгэх, тайлан боловсруулах тусгайлсан цахим мэдээллийн нэгдсэн санг нэвтрүүлж, дуудлага мэдээллийн дагуу ажиллах цагдаагийн алба хаагчид хүчирхийлэл үйлдэгчийн талаарх мэдээллийг урьдчилан мэдэх, цаашлаад хүчирхийлэл үйлдэгчид ял завших боломж олгохгүй байх, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээг тодорхойлоход ашиглан ажиллаж байна. Энэхүү санд Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байранд үйлчлүүлсэн хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүд, хүүхдийн мэдээллийг оруулах бөгөөд үр дүнд нь улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн бодит тоо мэдээлэл, хүчирхийллийн талаарх мэдээллийг тайлагнах боломжтой боллоо.

Мөн Цагдаагийн байгууллагын аймаг, дүүргийн бүх хэлтэст Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид зөвлөгөө өгөх өрөө байдаг. Харин хүүхдээс мэдүүлэг авах өрөө Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг дэх 1 дүгээр хэлтэст, Баянгол дүүрэг дэх 1 дүгээр хэлтэст тус тус ажиллаж байна. Мөн Нийслэлийн цагдаагийн газрын харьяа түр хамгаалах байранд 4 сэтгэл зүйч гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдүүдэд зөвлөгөө өгч, шаардлагатай үйлчилгээг үзүүлж байна.

Улсын хэмжээнд 2018 онд аймаг, дүүргийн цагдаагийн 30 хэлтэст хүүхдээс мэдүүлэг авах өрөөг улсын төсвийн хөрөнгөөр байгуулна.

Харилцаа холбоо, мэдээлэл, технологийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран олон нийтийн цахим сүлжээний орчин дахь хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө баталж, гар утасны дугаарыг бүртгэлжүүлэх ажлыг эхлүүллээ. Ингэснээр насанд хүрээгүй хүмүүсийг гар утасны дата ашиглан залилах, доромжлох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой.

Хүүхэд хамгаалал ажлын хүрээнд хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хотын түгжрэлийг сааруулахад чиглэсэн "Сургуулийн автобус"-ыг нийслэлийн 20 сургуульд туршилтын журмаар 14 хоног явуулсан бөгөөд цаашид үргэлжлүүлэх, төсөв хөрөнгийг шийдвэрлэх асуудлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн авто тээврийн газартай хамтран судалж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээг 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай, Хүүхдийн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг мөн оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай тус тус зохион явуулж байна

“Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээний үр дүнд 2018 оны 04 зүгээр сард цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн тоо 26,1 хувиар, сэжигтний тоо 47.6 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэргийн тоо 20,5 хувиар өмнөх оны мөн үеэс тус тус буурсан байлаа.

Хүүхдийг аливаа гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүмүүжлийн зөв хандлагад уриалах, эрх зүйн мэдлэг олгох зорилготой “Өсвөрийн сэргийлэгч” төслийг боловсруулж, “Сэргийлэгч хүү, зөвлөгч охин”-ны хүүхэлдэйн дүр, адал явдалт комик ном, 4 анги 2D хүүхэлдэйн кино, хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон 60 цуврал нэвтрүүлгийн зохиол, телевизийн нэвтрүүлэг хийж эхлээд байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт:

Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-ийг байгуулж, сард дунджаар 10 мянга гаруй дуудлага хүлээн авч, хүүхэд өсвөр үеийнхэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, хүүхэд хамгааллын шуурхай тусламж үзүүлэн ажиллаж байна. Уг төв 2017 онд хүүхдийн эрх, хамгааллын 3170 тохиолдлыг, 2018 оны 1 дүгээр улиралд 1320 тохиолдлыг аймаг орон нутгийн гэр бүл, хүүхэд залуучуудын газар/хэлтэс/, Хамтарсан багт шилжүүлж, 442 тохиолдлыг шийдвэрлэсэн байна. Түүнчлэн Засгийн газрын 2017 оны 231 дүгээр тогтоолоор “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр”-ыг байгуулснаас хойш 0-18 хүртэлх насны 561 хүүхдийг хүлээн авч хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлжээ.

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хурууны хээгээр Уралдаанч хүүхдийн мэдээллийн сан, Хүүхдийн зуслан, ордноор үйлчлүүлсэн хүүхдийн мэдээллийн сан, Халамж, асрамжийн төв, төвд амьдарч байгаа хүүхдийн мэдээллийн сан, Хараа хяналтгүй хүүхдийн мэдээллийн санг тус тус бүрдүүлээд байна.

Ингэснээр хурдан морины уралдаанч хүүхэд, хараа хяналтгүй хүүхэд, халамж, асрамжийн төвд амьдарч байгаа хүүхдийн шилжилт хөдөлгөөнийг хянах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа эсэх, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Зөрчлийн тухай хуульд заасан хүүхдийн эсрэг 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх, хууль сурталчлах чиг үүрэгтэй ажиллах хүүхдийн эрхийн улсын байцаагчийг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулж, Хүүхдийн эрхийн улсын байцаагчийг бэлтгэх сургалтад хамруулан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/181 тоот тушаалаар 32 төрийн албан хаагчид Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх олгосон.

Хүснэгт 3. 2017 оны байдлаар Хууль зүйн хороогоор үйлчлүүлсэн хүүхэд¹⁰

Үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо	Шийдвэрлэгдсэн тохиолдлын тоо		Шийдвэрлэгдээгүй тохиолдлын тоо		Нийт хурлын тоо	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
618	277	27	32	30	70	21

2018 онд Хүүхдийн эрхийн улсын байцаагч нар “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын дагуу дотуур байр, сүм хийд, интернет тоглоомын газруудад төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж, зөвлөн туслах, зөрчлийг илрүүлэх, шалгах, хууль сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй 609 Хамтарсан баг ажиллаж байна.

Хүснэгт 4. 2017 оны байдлаар Хамтарсан багийн үйлчилгээ, тоогоор¹¹

Дд	Үйлчилгээ	2017 он	2018 оны I улирал
1.	Шийдвэрлэсэн кейс	2197	-
2.	Ажиллаж байгаа кейс	2340	-
3.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй гэр бүлд	1298	1195
4.	Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ	1478	1366
5.	Аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ	800	277
6.	Нийгмийн халамжийн үйлчилгээ	1685	599
7.	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	945	1233
8.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	529	359
9.	Холбон зуучлах үйлчилгээ	936	451

Боловсролын салбарт:

2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 02 дугаар сарын 04-ний өдрийн хооронд зохион байгуулсан “Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол” улсын хоёрдугаар зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн үзэл баримтлалд тусгуулав.

Хүүхдийн эрхийн аливаа зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхцөл байдлыг бууруулах, боловсролын үйлчилгээг хүн сурталчгүй, чирэгдэлгүй болгох, аливаа ёс зүй, зөрчлийн асуудлыг цэцэрлэг, сургуулийн төвшинд хамтын оролцоотойгоор шийддэг болох зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/243 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад албан тушаалтны ёс зүйн дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам”-ыг тус тус шинэчлэн баталлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчин нөхцөл, хүүхдийн хөгжил, хамгааллын өнөөгийн байдлын судалгаанд суурилан “Дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулах дунд хугацааны төлөвлөө”-г батлууллаа. Ингэснээр дотуур байранд амьдарч буй хүүхдийн эрх, хамгаалал, тэдний орчин

¹⁰ Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

¹¹ Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

үйлчилгээг сайжруулах хүрээнд эцэг эх, орон нутгийн байгууллагуудын олон талт хамтын ажиллагааг уялдуулан, хамтран ажиллалаа.

Мөн Цэцэрлэг, сургууль, дотуур байрны сургалтын болон амьдрах орчны аюулгүй байдлыг хангахын тулд сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүү, хяналт шинжилгээ үнэлгээнд хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тусгайлан авч хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах ажлыг бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд зохион байгуулж байна.

Хоёр: Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт үр дүнгийн талаар:

Монгол Улсад хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн дийлэнх тохиолдлыг зөвхөн зөрчлийн хэмжээнд авч үзэж байсныг өөрчилж, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодох, харгис хэрцгий харьцах, догшин авирлах, тарчлаах зэрэг хүчирхийллийн зарим ноцтой үйлдлийг гэмт хэрэгт тооцон, ял шийтгэх зохицуулалтыг Эрүүгийн хуульд тусгаж, гэмт этгээдийг 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, мөн хугацааны хорих ялаар шийтгэхээр хуульчилсан.

Мөн Зөрчлийн тухай хуульд хүүхэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн талаар мэдээлээгүй болон түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, өөр зориулалтаар ашигласан, хамгаалах байрны журмыг зөрчиж нэвтэрсэн этгээдэд хариуцлага тооцох, гэр бүлийн хүчирхийллийн зарим тохиолдлыг зөрчилд тооцохоор заасан.


Улсын хэмжээнд 2017 онд 1,327,017 захиргааны зөрчил бүртгэгдсэний 4369 буюу 0.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж, зөрчил гаргасан 1480 хүнд 37,3 сая төгрөгөөр торгох, 2889 хүнд баривчлах шийтгэлийг Захиргааны хариуцлагын тухай хууль, Зөрчлийн тухай хуульд зааснаар тус тус оногдуулжээ.

2018 оны эхний улиралд 323,049 захиргааны зөрчил бүртгэгдсэний 930 буюу 0.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж, зөрчил гаргасан 9 хүнийг 1220.0 мянган төгрөгөөр торгож, 921 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.

Гурав: Хүний эрхийн үндэсний комиссын судалгааны үр дүнтэй холбоотой үйл ажиллагааны хүрээнд:

Хүний эрхийн үндэсний комисс, Гүүд нэйборс олон улсын байгууллагатай хамтран 2016 онд "Хүүхдийн эрх ба хамгаалал" сэдэвт хүүхдийн эрхийн мэдлэг, хандлага, хэрэгжилтийг тодорхойлох судалгааг хийж гүйцэтгэжээ. Уг судалгааны үеэр Хамтарсан багт хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох зорилгоор Хамтарсан багийн гишүүдээс ярилцлагын аргаар авсан мэдээлэл авсан байдаг.

График 8. Хамтарсан багт Хүүхдийн эсрэг зөрчил, хүчирхийллийг шийдвэрлэхэд тулгардаг бэрхшээл¹²



Энэхүү судалгаагаар Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхэд Хамтарсан багт тулгардаг бэрхшээлийг арилгах чиглэлээр:

1) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмыг баталж, Хамтарсан багийн гишүүдэд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн асуудлыг шийдвэрлэсэн.

2) Эцэг эх, олон нийтийн буруу хандлагыг өөрчлөх зорилгоор Гурван тулгуурт хөгжлийн бодлогын "Хүн төвтэй нийгмийн бодлого"-ын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан "Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-ийг 25.000 өрхөд хүргэж, гэр бүлийн боловсрол олгох, хүмүүжлийн зэрэг аргыг эзэмшүүлэх, Хүүхэд хамгааллын үйлчилгээг шинэ шатанд гаргаж, боловсронгуй болгох хүрээнд хүүхдийн эрх ба бизнесийн зарчимд суурилсан "Хүүхэд хамгааллын даатгалын үйлчилгээ"-г нэвтрүүлэх, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, Хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн эрх, эрүүл мэндийг бүх шатанд хамгаалах, компьютер болон дэлгэцэнд донтолтоос ангижруулах, хүүхдийн хүчирхийллийг арилгах цогц арга хэмжээ тус тус авлаа.

3) Хамтарсан багийн арга зүй, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2017 оныг "Хамтарсан багийг чадавхижуулах жил" болгон зарлаж, "Хамтарсан багийн сургагч багш бэлтгэх сургалт"-ыг зохион байгуулж, амжилттай суралцсан сургагч багш нарт Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтран баталсан гэрчилгээ гардуулсан.

Үүний дагуу төр болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр Хамтарсан багийн сургагч багш нараар 21 аймаг, 9 дүүргийн 609 Хамтарсан багийг 2017 оны эхний хагас жилд сургах, давтан сургах сургалтуудыг зохион байгууллаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд энэ жил боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын асуудалд анхаарал хандуулж,

¹² Хүний эрхийн үндэсний комисс, Гүүд нэйборс ОУБ-тай хамтран 2016 онд "Хүүхдийн эрх ба хамгаалал" судалгааны 51 дүгээр хуудас

хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, багш, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн “Жишиг сургууль”-ийн загварыг улсын хэмжээнд ерөнхий боловсролын 31 сургууль дээр туршин хэрэгжүүлнэ.

Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах стандартыг бий болгох, хамгаалалтад байх үед нийгмийн болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгох ажлын хүрээнд “Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах стандарт”-ын төслийг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын прокурорын ерөнхий газарт санал авч нэгтгэн, стандартыг төслийг батлуулах.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүрээнд хөршийн холбоог дэмжих, олон нийтийн байцаагч, хэсгийн байцаагчдыг хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд татан оролцуулах, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх ажлуудыг тус тус төлөвлөн хэрэгжүүлж байна.

-oOo-